



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/946

Мандалговь

Сургалтын төлбөрийн дэмжлэг
үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан батлах тухай 61 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Дундговь аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн 4.1.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутагт боловсролын салбарт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа болон зэрэглэл ахиулах магистрантын сургалтад хамрагдаж буй хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Төлбөрт шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Орон нутгийн хөрөнгө оруулалт “Хүний нөөцийг хөгжүүлэх” дэд хөтөлбөрийн зардлаас зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Доржбат), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100655

Дундговь аймгийн Засаг даргын 2023 оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт



СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ДЭМЖЛЭГТ ХАМРАГДАХ
АЛБАН ХААГЧДЫН НЭРС

№	Овог нэр	Албан тушаал	Сургалтын төлбөрийн мөнгөн дүн
1	Цолмон Цэцэгмаа	Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн бүлгийн багш	500,000
2	Дашням Баяржаргал	Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш	500,000
3	Эрдэнэчимэг Ганбодь	Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн туслах багш	500,000
4	Нямлхагва Сүрьеэрагчаа	Дэлгэрцогт сумын Хүүхдийн цэцэрлэгийн бүлгийн багш	500,000
5	Цолмон Сайн-Амгалан	Сайнцагаан сумын "Цэгц билиг" сургуулийн Математикийн багш	500,000
6	Баяржаргалын Эрдэнэцэцэг	Дэлгэрцогт сумын ЕБС-ийн номын санч	500,000
Нийт дүн:			3,000,000